

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 03 дугаар сарын мэдээ

2023.03.23

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: 03 сарын 04 нд Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалт, нутгийн уугуул Цэндийн Анхбаярын нэрэмжит бөхийн барилдаанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг ЗДТГазартай хамтарч зохион байгуулсан.

03 сарын 08-нд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажлын албаны болон ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчиддөө хүндэтгэл үзүүлсэн.

03 сарын 13-нд Сумын Удирдах ажилтны зөвлөгөөнөөр ИТХ-ын дарга, сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан.

ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ажлын албатай 2023 оны гүйцэтгэлийн гэрээг байгуулсан.

ИТХ-ын зөвлөлийг хуралдуулж зөвлөлийн журам баталж, 2023 онд хийх ажлын төлөвлөгөө хэлэлцсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хуралдаж 2023 онд хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан.

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Улс орон даяар хэрэгжиж буй "Энэ жилдээ - Эрүүл жиндээ" аяны нээлтийн үйл ажиллагааг эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж, албан байгууллага иргэдийн дунд холимог төрлөөр гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн "Энх мэндийн хадаг" сар шинийн нэгдсэн золголт, тус сумаас төрөн гарсан Монгол Улсын начин Цэндээгийн Анхбаярын нэрэмжит аймаг, цэргийн цолтой болон залуу 256 бөхийн барилдааныг МҮБХ-той хамтран амжилттай зохион байгууллаа.

"Хил хамгаалалтад туслах хүчний удирдах ажилтны зөвлөгөөнийг Хилийн дугаар ангитай хамтран зохион байгуулж, сумын хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

Хил хамгаалах байгууллагын 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Баатар Ч. Дугаржавын нэрэмжит, Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн дугаар анги нь сурагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр "Хилчин Кабинет"-ыг тохижууллаа.

03 дугаар сарын 13-нд сумын Удирдах ажилтны сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж Сумын ИТХ-ын дарга сумын засаг даргатай, төсөвт байгууллагын дарга нар сумын засаг даргатай, тамгын газрын даргатай засаг даргын тамгын газрын мэргэжилтнүүд гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хамтран ажиллах гэрээг байгуулж 2023 онд хийж ажлын чиглэлээ тодорхойллоо.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 3 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотариатаар баталгааж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан, малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарын дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Төсвийн газруудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хугацаанд нь e-balance программд шивж сумын нэгдсэн тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж , аудитын газар хүргүүлэхд билэн болсон байна .

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Хаврын хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга зөвлөмж бүхий зураг дүрст мэдээ мэдээллийг вэб хуудас болон сумын зар мэдээллийн facebook гурпүүдэд нийтэлж ажилласан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Тухайн сард нийт үзлэг - 458, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг – 180 иргэн, больницод хэвтэн эмчлүүлсэн –70 үүнээс хүүхэд – 32, . Алсын дуудлага – 18 ирсэнийг дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар- 72, лабораториор - 132 иргэнд шинжилгээ хийсэн. Өдрийн эмчилгээ – 22 хүнд стори нээж, эмчилгээг цаг тухай бүрт хийсэн

Рентгенд-52 үйлчлүүлэгчийн зургийг авсан. ЭХО-д – 35 иргэн харсан.

“Тууралтат халдварт өвчиний тухай”сургалтыг байрны багш, сургуулийн эмч нартаа хамтран сургалтыг зохион байгуулж хүүхдүүдэд /салхин цэцэг, улаанбурхан, гар хөл амны өвчин / гээд 3-н өвчинөөс урьдчилан сэргийлэх, илрэх шинж тэмдэг авах арга хэмжээ гэх мэт мэдлэг мэдээллийг өгөв. Нийт-48 хүүхдэд сургалтыг зохион байгуулсан.

“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд нээлтийн үйл ажиллааг хийж,төрийн болон төрийн бус байгууллагын нийт-235 хүнд халуун чацаргана өгч 54 хүний өндөр жинг үзэж биеийн жингийн индекс үзэж, дагал хөдөлгөөн, эрүүл зөв хооллолт, сүрьеэ өвчнөөс сэргийлэх, Элэгний В,С вирусын талаарх мэдээ, мэдээлэл өгч гарын авлага болон зөвлөгөө зөвлөмжийг нийт- 210 иргэнд үзүүлж, Артерийн даралт-35, Зүрхний бичлэг-5 иргэнд тус тус үйлчилгээ үзүүллээ.

Ерөнхий боловсролын сургууль:

Баяндэлгэр ЕБС-д хэрэгжиж байгаа "ASIA MONGOLIA" төслийг эцэг эх, суралцагч, багш нарт танилцуулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой "Мэдээллийн Технологийн хэрэглээ" өдөрлөгийг 03дугаар сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Төслийн талаар эцэг эх, 6-12 ангийн сурагчдад танилцууллаа.

Дугуйлангийн сурагчдын дунд кодны анхан шатны мэдлэг шалгах бага олимпиад зохион байгуулж амжилттай оролцсон сурагчдыг шагнаж урамшуулсан.

Хил хамгаалалтад туслах хүчний удирдах ажилтны зөвлөгөөн-2023"-ыг Хилийн цэргийн 0184 дүгээр ангитай хамтран зохион байгуулав. Зөвлөгөөнөөр сумын хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталж түүхийн кабинетад "Хилчин танхим"-ыг байгуулсан. Энэ нь суралцагчдыг цэрэг эх оронч хүмүүжил олгох болон мэргэжлээ сонгоход цэргийн анги салбарыг сурталчилсан чухал үйл ажиллагаа боллоо. Мөн Дайчин алдрын булангийн явуулын музей үзэсгэлэнг сум орны удирдлагууд болон сурагчдад үзүүлэв.

"Уран жиргээ-2023" уралдааны 1-р шатыг амжилттай зохион байгуулж, насны ангилалаар амжилттай оролцсон сурагчидаа шагнаж урамшуулсан.

"Уран жиргээ-2023" уралдааны 2-р шатанд тэргүүн байр эзэлсэн 3 сурагч Сүхбаатар аймагт амжилттай оролцлоо.

03 сарын 18-19-ны өдрүүдэд Байгалийн ухаан, Нийгмийн ухааны хичээлийн төрөлжсөн олимпиадад мэргэжлийн багш тус бүр суралцагчтайгаа Сүхбаатар аймагт амжилттай оролцлоо.

Цэцэрлэг: Хүүхдийн энэ сарын ирц 205-220 хооронд байна. Хүүхдийн өдөр тутмы үйл ажиллагаа тогтмол хэвийн явагдаж, бүлгийн багш болон туслах багш биеийн тамирын багш нар харилцан бие биенээсээ суралцах нээлттэй сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж ур чадвар аргагүйгээ дээшлүүлэн ажиллаж байна.

СӨБ багш нарын дунд нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй "Хүүхдийн хөгжлийн үнэлгээний аргагүй" цахим сургалтад 11 багш хамрагдаж байна.

ЭКО хөтөлбөрийн сургагч багш нар ажлын байранд сургалтыг зохион байгуулж өдөр тутмын сургалт үйл ажиллагаандаа зорилго, зорилтоос тусган хүүхдээ хөгжүүлэн ажилладаг, бүх багш ажилчид хамрагдсан.

НҮБ-ын хүүхдийн ивээх сантай хамтран "Бага насны хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болж монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлэлтийн чип багцыг гэрт сургалтын үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгүүд гардуулахаар шийдвэрлэж, чип багцаа гардан авсан.

Соёл: Соёлын төвийн номын сан нь байнгын уншигч 18, ирэгсэд 136 хүнд 113 ном гэрээр олгож 5 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 5 татгалзал бүртгэлээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Миний хөөрхөн ээжид..." захидлын уралдааныг 2 насны ангилалаар зохион байгууллаа. Уралдаанд нийт 28 захидал ирснээс насанд хүрэгчдийн төрөлд шилдэг 2 захидлыг сурагчдын төрөлд шилдэг 3 захидлыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

"Би ээжийнхээ он цагийн үргэлжлэл" фото зургийн уралдааныг цахимаар зохион байгууллаа. Уралдаанд нийт 43 хүн оролцож хамгийн олон хандалт авсан 2 зургийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Судар эгшиглэн-2023 төслийн 1-р шатанд оролцогчдыг бүртгэж, төсөлд уншигдах номыг фондоос татаж уншлаганд гаргах ажлыг зохион байгуулж байна.

Уншигч хүүхэд багачуудад номын тэмдэглэл хэрхэн хөтлөх, группд байршуулах талаар лавлагаа мэдээлэл% заавар зөвлөмж өгч уншигч нэг бүртэй тулж ажиллаж байна

Номын сангийн автоматжуулалтын Lib4U программд фондын номыг оруулах ажлыг хийж байна.

Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан аймгийн нийтийн номын сан, Сүхбаатар аймгийн МЗЭ-ийн салбар зөвлөлөөс хамран зохион байгуулсан Яруу эгшиг-2023 шинэ шүлгийн уншлагад яруу найрагч У.Буд, Б.Аръяа нарын хамт оролцлоо.

Эх орончдын өдрийг тохиолдуулан хөгжөөнт тэмцээн үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа.

Ахмадын “Дуулах өдөр - дуун цэнгүүн” - ийг зохион байгуулж ардын уламжлалт оньсон тоглоом, монгол зангилаа тайлах тэмцээн уралдааныг зохион байгуулж үдшийн цэнгүүн зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Бүсгүйчүүддээ” дан эрчүүд оролцсон тоглолт, “ ” зохион байгууллаа.

Монгол цэргийн өдөр ЗХ-ний 102 жилийн ойд зориулсан “Эр хүн танаа” хөтөлбөрт цэнгүүн зохион байгууллаа.

Ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 4 удаа үнийтийн бүжиг цэнгүүн зохиолоо.

XJ интертаймент хамлагийн “Онцгой хүсэл” хүүхдийн тоглолт, МУСТА Б.Отгончимэгийн “Цоглог байгаарай”, МУСТА Т.Ганбүргэдийн “Prady Show”хошин элэглэлийн тоглолтыг хүлээн авч ард иргэдэд хүргэлээ.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчины чиглэлээр: Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээг сумын Засаг даргын захирамжаар батлуулан, цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсгийг томиллоо. Бүх нийтийн их цэвэрлэгээнд идэвхтэй хамрагдахыг айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгж нарт уриалан ажиллаж байна.

Хөдөөгийн болон сумын төвийн үхсэн малын сэг зэмийг устгах ажлын хэсэг 2023 оны 03 сарын 07 ны өдрийн 29 тоот захирамжаар томилогдон сэг зэмийг усгах ажил явагдаж байна.Одоогоор 912 бод, 3200 бог малын сэг зэмийг ариутгал халдваргүйжилтийг хийж устгалд оруулаад байна.

Хуурайшилтын нэн аюултай, аюултай зэрэг бий болсон үед эргүүл, шалгалт хийх, шаардлагатай газар нутагт хяналтын цэг ажиллуулах хуваарь гарган захирамж төлөвлөн ажиллаж байна. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ажлын хэсэг төлөвлөгөө гаргаж сумын төвийн болон хөдөө багийн өнжмөл шар өвс хадгалж буй иргэдтэй уулзаж, аюулгүй байдлаас сэргийлэх зөвлөмж хүргэж ажиллаа. Нийт 51 өрхийн 2000 боодол өвсийг аюулгүй газарт хадгалуулах арга хэмжээг авлаа. Мөн mass messages –ээр хаврын хуурайшилтай холбоотой болон цаг агаагрын мэдээг 700 өрхөд тухай бүр явуулж байна

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2022 оны жилийн эцсийн мал тооллогын тоон мэдээллийг статистикийн мэдээлэл, мал эмнэлгийн гэрчилгээтэй тулгалт хийж системд оруулсан.

Хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан Дорнод аймгийн Матад сумтай гэрээ хийсний дагуу 1221 боодол өвс худалдан авч нэг боодол өвсийг 3000 төгрөгөөр хөнгөлж 11000 төгрөгөөр малчдад олгосон. 7 хоног бүрийн 3 дахь өдөр аймгийн ХХААГазарт том малын зүй бус хорогдол, мал төлөлт, төл бойжилтын мэдээг хүргүүлж байна.

Сумын хэмжээнд нийт 8949 толгой мал төллөсөн. Үүнд: ингэ – 7, гүү -27, үнээ -49, эм хонь – 6697, ямаа – 2169, Том малын хорогдол бүгд 21578 тэмээ- 0, адуу -1176, үхэр- 1378, хонь – 9263, ямаа- 9761

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн